



МОНГОЛ ТАМГА" ТӨҮГ-ЫН
ДАРГА Д.РЭНЦЭНТАВХАЙ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.15 № 3/437
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Монгол тамга" ТӨҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

"Монгол тамга" ТӨҮГ-ын удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

"Монгол тамга" ТӨҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Монгол тамга" ТӨҮГ-ын санхүүгийн тайлан, түүний тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

- Тайлант оны борлуулалтын орлогыг НӨАТ-ын тайланд 129.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Бусдаар гүйцэтгүүлсэн бараа, ажил үйлчилгээний орлогоос 0.2 сая төгрөгийн ХХОАТ-ын суутган тооцоолол хийгээгүй;
- Тайлант онд холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр 1.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө олж бэлтгэсэн;

- Монгол тамга ТӨҮГ-ын удирдлага цалингийн урьдчилгаа 4.1 сая төгрөг, орон сууцны зээл төлөхөд 6.1 сая төгрөг, хүүхдийн сургалтын төлбөр төлсөн 1.0 сая төгрөг мөн урьдчилж төлсөн зардалд бүртгэлтэй 17.2 сая төгрөгийн үнэ бүхий 2800 м2 газрыг өөрийн эзэмшилд шилжүүлсэн;
- Ажилтан албан хаагчдын ээлжийн амралтын цалинг бодохдоо унаа хоолны мөнгө 3.2 сая төгрөгийг дундаж цалинд оруулж тооцсон;
- Санхүүгийн тайланд тусгагдсан 54.3 сая төгрөгийн авлага, 84.0 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй;
- Тайлант онд 3.7 сая төгрөгийн шатахууныг данс бүртгэлд тусгалгүй шууд зардлаар тайлагнасан;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 32.7 сая төгрөгийн ажил гүйлгээг санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан;
- Монгол тамга ТӨҮГ-ын нягтлан бодогч нь байгууллагын дотоод журмыг зөрчиж байгууллагаас өөрийн хүүхдийн сургалтын төлбөрт 2.0 сая төгрөгийг төлсөн зэрэг нийт 98.1 сая төгрөгийн материаллаг зөрчил байна

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.


Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол "Монгол тамга" ТӨҮГ-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

В. М

Ц.НАРАНЧИМЭГ





УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

“МОНГОЛ ТАМГА” ТӨҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

САГ-ын дарга,
Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг:
Naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер:
Я.Самбууням
Утас: 260512
Цахим хаяг:
Sambuunyamyа@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Батсайхан
Утас: 260512
Цахим хаяг:
batsaikhann@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар
Байршил: Чингэлтэй дүүрэг ЗГ-ын
4-р байр
Цахим хуудас: www.audit.mn

“Б энд С Аудит” ХХК
Захирал Д.Дашхорлоо
Утас: 70114810
Цахим хаяг:
audit_bc@yahoo.com

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ
Хавсралт 2: Менежментийн захидал
Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн
тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдлын түвшин
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Монгол тамга” ТӨҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ. /САГ/2017/76/СТА-ТӨҮГ/

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Монгол тамга” ТӨҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарттүүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт оршино.

“Монгол тамга” ТӨҮГ нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаа СТОУС түүнд нийцүүлсэн Сангийн Сайдын баталсан холбогдох журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Монгол тамга” ТӨҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 09 дүгээр сарын 26-нд завсрын, 2017 оны 2 дугаар сарын 05-наас 21-ийг хүртэл хугацаанд жилийн эцсийн аудитыг хийхээр төлөвлөн “Б энд С Аудит” ХХК-ын аудитын III багийн ахлах аудитор Ц.Жамъянхорол, аудитор С.Алтанцэцэг, аудиторов туслах Б.Эрдэнэтогтох нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Монгол тамга” ТӨҮГ 2017 оны 02 дугаар сарын 07-ны 1/54 дугаар албан бичгээр 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгүүлэхээр “Б энд С Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 15-нд “Монгол тамга” ТӨҮГ-ын удирдлагад гардуулав.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Монгол тамга” ТӨҮГ нь Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн аудитын тухай, ААНОАТ-ын тухай, НӨАТ-ын тухай, Нийгмийн даатгалын тухай, ХХОАТ-ын тухай, Цагдаагийн тухай, Шилэн дансны тухай хуулиуд болон эдгээр хуулиудтай нийцүүлэн гаргасан Засгийн газрын тогтоол, Сангийн Сайдын тушаал, бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

“Монгол тамга” ТӨҮГ-ын үйл ажиллагааны үндсэн зорилт нь Монгол улсын хууль тогтоомж төрийн өмчийн хорооноос өгсөн зорилтод түвшингийн үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллахад оршино гэж байгууллагын чиг үүргийг тодорхойлсон байна. Үйл ажиллагааны чиглэл нь ХЗДХЯ-ны тусгай зөвшөөрлөөр тамга тэмдэг үйлдвэрлэх, түүнд нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн үйл ажиллагаа эрхлэх явдал юм.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд тухайн байгууллага нь санхүүгийн тогтвортой байдлыг хангаж, техник технологийг сайжруулах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, өртөг зардлыг хямдруулах, өр авлагыг бууруулан, бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, үр ашигтай удирдлагаар хангаж ажиллах үүрэгтэй байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д заасны дагуу төсвийн шууд захирагч “Монгол тамга” ТӨҮГ-ын төсвийг захиран зарцуулж байна.

“Монгол тамга” ТӨҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудитхийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Монгол тамга” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт, хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 10-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Монгол тамга” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллаагүй байна.

“Монгол тамга” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Монгол тамга” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “Лидер” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдлын түвшин

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт зардлын 2 хувиар тогтоож, хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 4.1 сая төгрөг гэж тооцов. Учир нь: Нийт орлого болон зардлаас материаллаг түвшинг тогтооход материаллаг түвшин өндөр гарч байгаа тул нийт зардлын 2 хувиар материаллаг байдлын түвшинг тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

Дотоод хяналт

Аудитор санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хяналаа.

Ийнхүү хянахдаа “Монгол тамга” ТӨҮГ-ын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтыг санхүүгийн, хяналтын эрсдэл байвал зохих горимтой харьцуулан шалгаж үзсэн. Үүний үр дүнд удирдлагаас зайлшгүй хэрэгжүүлэх дотоод хяналт ямар байгааг тогтоосон. Аудитор байгууллагын удирдлагад бүртгэл санхүүгийн үйл ажиллагаа, тайлагнал, дотоод хяналтад илэрсэн сул талуудыг тухай бүрд нь мэдэгдэж зөвлөмж өгч ажилласан.

Орлого, зардал, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

“Монгол тамга” ТӨҮГ нь 2016 оны зорилтот түвшингийн төлөвлөгөөг Төрийн өмчийн хороогоор батлуулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаагүй байна. Байгууллагын саналаар 2016 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн зорилтот түвшинг хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр нийт орлогыг 175.0 сая төгрөг, нийт зардлыг 199.5 сая төгрөг байхаар тооцож, гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого 197.5 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 0.2 сая төгрөг, нийт 197.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 12.9 хувиар буюу 22.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Тайлант хугацаанд борлуулсан бүтээгдэхүүний өртөг 33.7 сая төгрөг, борлуулалт маркетинг удирдлагын зардалд 159.0 сая төгрөг, бусад зардалд 14.1 сая төгрөг, нийт 206.8 сая төгрөг зарцуулж батлагдсан зорилтод түвшингээс 4.5 хувиар хэтрүүлж, 9,156.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Шилэн дансны мэдээлэл

Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 394-р тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох” тухай журмыг дагаж мөрдөөгүй тулямар ч гүйлгээний оруулаагүй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 дансанд эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын 10 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Аудитын гүйцэтгэлээр төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж авч үзсэн эрсдлүүдээс мөнгөн хөрөнгө, авлага, цалин хөлс зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, “иж бүрэн байх”,

“хамааралтай байх”, “эрх ба үүрэг”, “үнэлгээ”, “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

“Монгол тамга” ТӨҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материал, авлага, өглөг, үндсэн хөрөнгө, орлого, тээвэр шатахуун, бичиг хэрэг, албан томилолт, цалин хөлс зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа./ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлого, зардал, хөрөнгийн 81.6 хувийг эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад дараах алдаа зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Тайлант оны борлуулалтын орлогыг НӨАТ-ын тайланд 129.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан нь НӨАТ-ын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д “Бараа, ажил, үйлчилгээг импортолсон буюу экспортолсон, түүнчлэн борлуулсан бол тухай бүрт” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Илэрсэн зөрчлийг холбогдох ажилтнуудад асуудлын бүртгэлээр танилцуулж, удирдлагад албан шаардлага хүргүүлэв.

2. Бусдаар гүйцэтгүүлсэн бараа, ажил үйлчилгээний орлогоос 0.2 сая төгрөгийн ХХОАТ-ын суутган тооцоолол хийгээгүй нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4-т “Шууд бус орлогод ноогдуулах албан татварыг тухайн орлогын дүнгээр” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

3. Тайлант онд холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр 1.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө олж бэлтгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар өөрийн чиг үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг санхүүгийн жил эхлэхээс 3 сарын өмнө гаргаж, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сангийн яамаар зардлын дээд хязгаарыг батлуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

4. Монгол тамга ТӨҮГ-ын удирдлага өөртөө тушаал гаргажцалингийн урьдчилгаанд 4.1 сая төгрөг, орон сууцны зээл төлөхөд 6.1 сая төгрөг, хүүхдийн сургалтын төлбөрт 1.0 сая төгрөг, 17.2 сая төгрөгийн үнэ бүхий 2800 м² газрыг өөрийн эзэмшилд шилжүүлж авлагаар бүртгэсэн, мөн нягтлан бодогчийн хүүхдийн сургалтын төлбөрт 2.0 сая төгрөг олгосон зэрэг нийт 30.4 сая төгрөгийг зөрчил нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Албан тушаалтан иргэний болон хуулийн этгээдийн зүгээс тавьсан албан үүрэгтэй нь зөрчилдөх хувийн ашиг сонирхлын асуудал болон зан байдлыг тэвчиж, албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг хувийн болон тусгай ашиг сонирхлоос илүүд үзнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Илэрсэн зөрчлийг холбогдох ажилтнуудад асуудлын бүртгэлээр танилцуулж, удирдлагад төлбөрийн акт тогтоов.

5. Ажилтан албан хаагчдын ээлжийн амралтын цалинг бодохдоо унаа хоолны мөнгө 3.2 сая төгрөгийг дундаж цалиндоруулж тооцсон нь нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн Сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох” журмын 4-т “Ажилтанд олгож байгаа бүх төрлийн /жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвараа алдсаны, ажилгүйдлийн, тэтгэвэрт гарах үеийн ажилтанд олгох гэх мэт/ тэтгэмжүүд, нөхөх олговор, хөнгөлөлтийн орлого, унаа, түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлт/-ыг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Илэрсэн зөрчлийг холбогдох ажилтнуудад асуудлын бүртгэлээр танилцуулж, удирдлагад албан шаардлага хүргүүлэв.

6. Санхүүгийн тайланд тусгагдсан 54.3 сая төгрөгийн авлага, 84.0 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байгаань Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах, ажлыг зохион байгуулах удирдах” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

7. Тайлант онд 3.7 сая төгрөгийн шатахууныг данс бүртгэлд тусгалгүй шууд зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 9 дүгээр зүйлийн 9.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана”, НББОУС 2 *Бараа материал*–д заасны дагуу бараа материалыг өртөг болон цэвэр боломжит үнийн аль багаар нь үнэлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

8. Анхан шатны баримтын бүрдэл дутуу 32.7 сая төгрөгийн ажил гүйлгээг санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Монгол тамга ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар НӨАТ-ын тайланд борлуулалтын орлогыг 129.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасанд холбогдох ажилтнуудад танилцуулж залруулахыг зөвлөсөн боловч хэрэгжээгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

“Монгол тамга” ТӨҮГ-ын удирдлага нь өмнөх аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, төлбөрийн актыг биелүүлээгүй, өмнөх зөрчил дахин давтагдаж, төсвийн хөрөнгийг удирдлага дур мэдэн зарцуулж байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Албан тушаалтан иргэний болон хуулийн этгээдийн зүгээс тавьсан албан үүрэгтэй нь зөрчилдөх хувийн ашиг сонирхлын асуудал болон зан байдлыг тэвчиж, албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг хувийн болон тусгай ашиг сонирхлоос илүүд үзнэ” гэсэн заалтыг зөрчиж байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Монгол тамга” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал үгүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Монгол тамга” ТӨҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 340.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 132.9 сая төгрөг талбан шаардлага өгч, 30.7 сая төгрөгт төлбөрийн акт тогтоон, 176.6 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Монгол тамга” ТӨҮГ-ын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 5 зөвлөмж, 2 төлбөрийн акт тогтоосныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Монгол тамга ТӨҮГ-ын 2015 оны санхүүгийн аудитаар нийт 67.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 186.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол “Монгол тамга” ТӨҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн

Сангийн Сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, 4 хавсралтууд хавсаргав



“МОНГОЛ ТАМГА” ТӨҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Суутган тооцооллынталаархуудас 3

Асуудал 2

Үндсэн хөрөнгийн талаархуудас 4

Асуудал 3

Цалингийн зардлын талаархуудас 5

Асуудал 4

Авлага, өр төлбөрийн талаар.....хуудас 6

Менежментийн захидал

“Б энд С Аудит” ХХК аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Монгол тамга” ТӨҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Монгол тамга” ТӨҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

“Б энд С аудит” ХХК-н ажиглалт

Хувь хүнд 0.2 сая төгрөгийн бусдаар гүйцэтгүүлсэн бараа, ажил үйлчилгээний төлбөрийг олгохдоотатварын суутган тооцоолол хийгээгүй нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4-т “Шууд бус орлогод ноогдуулах албан татварыг тухайн орлогын дүнгээр” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

“Б энд С аудит” ХХК-н зөвлөмж

Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах

Эрсдэлүүд

Холбогдох хууль, тогтоомж, заавар, журмыг зөрчсөн байх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага санхүүгийн ажилтнуудад танилцуулж баталгаажуулсан болно.

“Б энд С аудит” ХХК-н ажиглалт

Тайлант онд холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр 1.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө олж бэлтгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар өөрийн чиг үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг санхүүгийн жил эхлэхээс 3 сарын өмнө гаргаж, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сангийн яамаар зардлын дээд хязгаарыг батлуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна

“Б энд С аудит” ХХК-н зөвлөмж

Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах

Эрсдэлүүд

Холбогдох хууль, тогтоомж, заавар, журмыг зөрчсөн байх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага санхүүгийн ажилтнуудад танилцуулж баталгаажуулсан болно.

“Б энд С аудит” ХХК-н ажиглалт

Ажилтан албан хаагчдын ээлжийн амралтын цалинг бодохдоо унаа хоолны мөнгө 3.2 сая төгрөгийг дундаж цалинд оруулж тооцсон нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн Сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Дундаж цалин хөлс тодорхойлох" журмын 4-т "Ажилтанд олгож байгаа бүх төрлийн /жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвараа алдсаны, ажилгүйдлийн, тэтгэвэрт гарах үеийн ажилтанд олгох гэх мэт/ тэтгэмжүүд, нөхөх олговор, хөнгөлөлтийн орлого, /унаа, түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлт/-ыг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

“Б энд С аудит” ХХК-н зөвлөмж

Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах

Эрсдэлүүд

Холбогдох хууль, тогтоомж, заавар, журмыг зөрчсөн байх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага санхүүгийн ажилтнуудад танилцуулж баталгаажуулсан болно.

“Б энд С аудит” ХХК-н ажиглалт

Санхүүгийн тайланд тусгагдсан 54.3 сая төгрөгийн авлага, 84.0 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах, ажлыг зохион байгуулах удирдах” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

“Б энд С аудит” ХХК-н зөвлөмж

Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах

Эрсдэлүүд

Холбогдох хууль, тогтоомж, заавар, журмыг зөрчсөн байх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага санхүүгийн ажилтнуудад танилцуулж баталгаажуулсан болно.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө	10,639,000.69	26,318,895.90
<i>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө</i>	156,868,228.20	177,892,821.20
Дансны авлага	1,085,566.81	1,056,468.90
Татвар, НДШ-ийн авлага	1,070,000.00	1,070,000.00
Бусад авлага	55,287,962.78	55,236,485.48
Бараа бэлэн бүтээгдэхүүн	17,200,000.00	
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо		
Бусад богино хугацаат өр төлбөр	242,150,758.48	261,574,671.48
Эргэлтийн хөрөнгийн дүн		
Эргэлтийн бүс хөрөнгө	58,870,336.86	42,338,554.82
<i>Үндсэн хөрөнгө</i>	484,819.33	295,166.67
Биет бүс хөрөнгө		
Биологийн хөрөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Бусад эргэлтийн бүс хөрөнгө		
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	59,355,156.19	42,633,721.49
Эргэлтийн бүс хөрөнгийн дүн	301,505,914.67	304,208,392.97
Нийт хөрөнгө		
Богино хугацаат өр төлбөр	2,189,500.00	2,189,500.00
<i>Дансны өглөг</i>		282,559.76
Орлогын татварын өглөг	22,329,243.16	35,555,542.17
ХАОАТ-ын өглөг		
НӨАТ-ын өглөг		
Цалингийн өглөг	1,259,636.70	
ЭМНД-ын шимтгэлийн өглөг	8,722,310.50	8,722,310.50
Нөөц өр төлбөр	36,999,734.00	36,999,734.00
Бусад богино хугацаат өр төлбөр		
Урьдчилж орсон орлого	71,500,424.36	83,749,646.43
Богино хугацаат өр төлбөрийн дүн		
Урт хугацаат өр төлбөр	185,152,416.47	139,000,000.00
<i>Урт хугацаат зээл</i>		
Бусад урт хугацаат өглөг		
Урт хугацаат өр төлбөрийн дүн	71,500,424.36	83,749,646.43
Өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө	46,645,097.40	46,645,097.40
<i>Төрийн</i>		
Хувийн		
Халаасны хувьцаа	12,366,998.00	12,366,998.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
Эздийн өмчийн хэсэг	170,993,394.91	161,446,651.14
Хуримтлагдсан үр дүн	170,993,394.91	- 9,546,743.77
Тайлангийн үеийн ашиг		170,993,394.91
Өмнөх үеийн ашиг	230,005,490.31	220,458,746.54
Эзэмшигчдийн өмчийн дүн	301,505,914.67	304,208,392.97
Нийт өр төлбөр ба эзэмшигчийн өмч	-	

Байгууллагын нэр: Монгол тамга ТӨҮГ
 Бэлтгэсэн огноо: 2017.01.30
 Тайлант хугацаа: 2016.12.31

АУДИТ ХИЙГДСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Өмнөх он	Тайлант он
Борлуулалтын орлого	201,825,681.82	197,487,829.09
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	50,537,586.80	33,712,724.30
Нийт ашиг	151,288,095.02	163,775,104.79
Түрээсийн орлого		
Хүүгийн орлого	3,180,382.20	167,453.47
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого		
Борлуулалт маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	180,064,939.04	158,972,062.47
Санхүүгийн зардал	191,600.00	2,897,200.00
Бусад зардал	34,141,600.00	11,230,000.00
Гадаад валютын хашийн зөрүүний олз /гарз/		
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	- 655,652.50	
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		
Хөрөнгө оруулалт борлуулалтаас үүссэн олз /гарз/		
Бусад ашиг /алдагдал/		
Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	- 59,274,009.32	- 9,156,704.21
Орлогын татварын зардал		390,039.57
Татварын дараах ашиг /алдагдал/	- 59,274,009.32	- 9,546,743.78
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/		
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	- 59,274,009.32	- 9,546,743.78
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	- 59,274,009.32	
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз /гарз/		-
Орлогын нийт дүн	- 59,274,009.32	- 9,546,743.78
Нэгж хувьцааны ногдох суурь ашиг /алдагдал/		

Байгууллагын нэр: Монгол тамга ТӨҮГ
Бэлтгэсэн огноо: 2017.01.30
Тайлант хугацаа: 2016.12.31

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Өмнөх он	Тайлант он
<i>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</i>		
Мөнгөн орлогын дүн	226,607,791.70	218,861,316.00
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	222,314,050.00	218,347,062.00
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	3,034,405.00	514,254.00
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	1,259,336.70	
Мөнгөн зарлагын дүн	252,797,527.86	192,433,446.26
Ажилчдад олгосон мөнгө	109,752,150.00	75,238,688.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	20,460,909.86	20,653,614.11
Бараа материал худалдан авахав төлсөн	62,257,730.00	35,739,197.00
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	17,402,580.00	15,412,600.00
Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	5,234,370.00	6,057,900.00
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	6,907,335.00	14,946,983.80
Даатгалын төлбөрт төлсөн		
Бусад мөнгөн зарлага	30,782,453.00	24,384,463.35
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	- 26,189,736.16	26,427,869.74
<i>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</i>		
Мөнгөн орлогын дүн	43,230,382.20	227,453.47
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсаны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого	40,050,000.00	60,000.00
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого	3,180,382.20	167,453.47
Хүлээн авсан ногдол ашиг		
Мөнгөн зарлагын дүн	106,787,750.00	10,975,428.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,937,750.00	1,885,000.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	33,000,000.00	
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	69,850,000.00	9,090,428.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	- 63,557,367.80	- 10,747,974.53
<i>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</i>		
Мөнгөн орлогын дүн	-	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг		
Мөнгөн зарлагын дүн	7,920,000.00	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Хувьцаа буцаан худалдаж төлсөн		
Төлсөн ногдол ашиг	7,920,000.00	
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	- 7,920,000.00	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	48,562,123.55	21,024,593.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	108,306,104.65	156,868,228.20
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	156,868,228.20	177,892,821.20

Байгууллагын нэр: Монгол тамга ТӨҮГ

Бэлтгэсэн огноо: 2017.01.30

Тайлант хугацаа: 2016.12.31

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

		Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн /төгрөг/
Аудит хийгдээгүй	2015 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	46,645,097.40	-	170,993,394.91	220,458,746.54	438,097,238.85
	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
	Залруулсан үлдэгдэл	46,645,097.40	-	170,993,394.91	220,458,746.54	438,097,238.85
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл					
	Гаргасан хувьцаа	-				-
	Тайлант үеийн ашиг	-			170,993,394.91	170,993,394.91
	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	46,645,097.40	-		391,452,141.45	438,097,238.85
Аудит хийгдсэн	2015 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	46,645,097.40	-	170,993,394.91	220,458,746.54	438,097,238.85
	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
	Залруулсан үлдэгдэл	46,645,097.40	-	170,993,394.91	220,458,746.54	438,097,238.85
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-		-	-	-
	Гаргасан хувьцаа	-		-	-	-
	Тайлант үеийн ашиг	-		-	170,993,394.91	170,993,394.91
	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	46,645,097.40	-		391,452,141.45	438,097,238.85